

ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламжийг хот, суурин газрын цахилгааны шугам сүлжээ, эх үүсвэрийн техникийн боломж, ерөнхий төлөвлөлт, техник-технологийн шинэчлэлтийн үйл ажиллагаатай уялдуулан төвлөрсөн цахилгаан хангамжийн системд холбоход техникийн нөхцөл олгох журмын зорилго оршино.
- 1.2. Эрчим хүчний шинээр баригдах, болон шинэчлэгдэх, өргөтгөл, засвар үйлчилгээ хийх барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах техникийн нөхцөл олгох, зураг төслийн ажлын гүйцэтгэл, барилга угсралтын ажилд хяналт тавих, барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авахад энэ журмыг мөрдлөг болгоно.
- 1.3. Иргэн, хуулийн этгээдээс барилга байгууламжиндаа цахилгаан шугам сүлжээнд холбуулахын тулд заавал хангах техникийн цогц шаардлагыг “Техникийн нөхцөл” гэнэ.

Хоёр. Техникийн нөхцөл олгох үндэслэл

- 2.1. Техникийн нөхцөлийг Улаанбаатар хот болон төвийн системд холбогдох хэрэглэгчид, ДБЭХС, Дөргөний УЦС, ББЭХС ороод 1 МВт чадал, Тайширын УЦС, Даланзадгадын ДЦС-ын хэрэглэгчид 0.5 МВт-аас дээш шинээр баригдах барилга байгууламжид цахилгаан авах, ачааллыг нэмэгдүүлэх болон сүлжээний горим ажиллагаанд нөлөөлөхүйц технологийн шинэчлэлт хийх тухай бүр Эрчим хүчний яамны /техникийн нөхцөл олгогч/-ын техникийн нөхцөл олгох комисс /ажлын хэсэг/-ын хурлаар, дээрхи ачааллаас бага тохиолдолд тухайн орон нутгийн эрчим хүчний байгууллагын техникийн нөхцөл олгох комиссын хурлаар тус тус шийдвэрлэж олгоно.
- 2.2. Улсын төсвийн тухай хууль, Засгийн Газрын мөрийн хөтөлбөр, “Эрчим хүчний нэгдсэн систем” хөтөлбөр, Эрчим хүчний мастер төлөвлөгөөнд тусгагдсан тухайн жилд шинээр баригдах, болон шинэчлэгдэх, өргөтгөл, засвар үйлчилгээ хийх эрчим хүчний барилга байгууламжуудын жагсаалт, хөрөнгө оруулалтын арга хэмжээний төслийн зураг төсөл боловсруулах техникийн нөхцөл олгох жагсаалт гарган комиссын хурлаар шийдвэрлүүлнэ.
- 2.3. Техникийн нөхцөл олгох журамыг Сайдын тушаалаар баталж, Эрчим хүчний яамны техникийн нөхцөл олгох комиссын бүрэлдэхүүнийг Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар, орон нутгийн цахилгааны эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн техникийн нөхцөл олгох комиссын бүрэлдэхүүнийг гүйцэтгэх захирлын тушаалаар тус тус томилно.

2.4. Ажлын хэсэг нь төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн захиргаа болон тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй тусгай зөвшөөрөл эзэмшигчийн төлөөллийг оролцуулсан бүрэлдэхүүнтэй байна

Гурав. Техникийн нөхцөл олголт

- 3.1. Хэрэглэгчдэд цахилгааны техникийн нөхцлийг уг барилга байгууламжийг шинээр барих, шинэчлэх тухай удирдах дээд газрын шийдвэр болон барилгын байршил тогтоосон газар олголтын тогтоолыг үндэслэнэ.
- 3.2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдах барилга байгууламжид цахилгааны техникийн нөхцөлийг уг барилга байгууламжийг шинээр барих, шинэчлэх тухай удирдах дээд газрын шийдвэр болон уг объектийн техник эдийн засгийн үндэслэл, салбарын шинжлэх ухаан техникийн зөвлөлийн шийдвэрийг үндэслэн олгоно.
- 3.3. Техникийн нөхцөл олгогч нь тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд газар эзэмшүүлэх тухай аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжаар хэд хэдэн объектод хамтатган олгосон тохиолдолд тэдгээр объектуудыг бүхэлд нь хамарсан нэгдсэн шугам сүлжээ, дэд станц барих боломжийг судлан үзэж техникийн нөхцөлийг олгоно.
- 3.4. Тухайн жилийн эхэн буюу төгсгөлд дамжуулах, түгээх дэд станцууд дээрхи цахилгаан эрчим хүчний чадлын нөөцийг тодорхойлон гаргаж комиссын хурлаар хэлэлцүүлэн батлана.
- 3.5. Иргэн, хуулийн этгээдийн объект нь зураг төслийн явцад цахилгаан ачаалал нь анхны авсан техникийн нөхцөлд заасан хүчин чадлаас 20 хувиар нэмэгдсэн тохиолдолд техникийн нөхцөлийг дахин авна.
- 3.6. Техникийн нөхцөлийг боловсруулахдаа харъяа цахилгаан дамжуулах, түгээх сүлжээ болон бусад иргэн, хуулийн этгээдийн өмчлөлийн шугам, тоног төхөөрөмжөөр дамжуулан объектыг холбох тохиолдол бүрт зөвшөөрөл авч баталгаажуулсан байна.
- 3.7. Техникийн нөхцөл хүсэж буй аж ахуйн нэгж, иргэд дараахь материалыг бүрдүүлнэ. Үүнд:
 - 3.7.1. Өргөдөл буюу албан хүсэлт
 - 3.7.2. Техникийн нөхцөл олгогчоос өгсөн тодруулах хуудас (хавсралт1)
 - 3.7.3. Тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд Засаг даргын “Барилгын байршилт тогтоож, газар ашиглуулах эрх олгох” тухай захирамж, шийдвэр
 - 3.7.4. Техникийн нөхцөл олгох ажлын хэсэг нь барилга объектын баригдах байршлыг газар дээр нь судалж захиалагчаас ирүүлсэн цахилгааны ачаалал, шугам сүлжээнд холбох хүсэлтийг цахилгаан шугам сүлжээний өнөөгийн болон ойр, хэтийн төлөвлөлтийн нөхцөл байдалтай уялдуулан хот, аймгийн төвийн хэтийн төлөв, инженерийн тооцоо судалгааг үндэслэсэн техникийн дүгнэлтийг хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэнэ.

- 3.8. Ажлын хэсэг нь техникийн нөхцөл олгохдоо энэхүү зааврын хавсралтад үзүүлсэн маягтын дагуу бөглөх бөгөөд, нэг хувийг архивт хадгална.
- 3.9. Техникийн нөхцөлийн хүчин төгөлдөр байх хугацааг объектод гүйцэтгэх ажлын хэмжээнээс хамааран 1-3 жилээр тогтооно.
- 3.10. Техникийн нөхцлийг эрчим хүчний ашиглалтын байгууллагаас авсан санал, болон ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн, Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулалтын газрын Эрчим хүчний хэлтсийн техникийн нөхцөл хариуцсан мэргэжилтэн боловсруулж ажлын хэсгийн гишүүд албажуулж гарын үсэг зурна.
- 3.11. Хотын цахилгаан хангамжийн системийн эх үүсвэр, шугам сүлжээний дамжуулах чадвар хүрэлцэхгүй шугам сүлжээнд холбогдох хэрэглэгчдэд техникийн нөхцөл олгохоос татгалзана.
- 3.12. Хэрэглэгчдийг цахилгааны эрчим хүчээр хангах холболтын техникийн нөхцлийг захиалагчийн албан бичиг тодруулах хуудсыг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор олгоно.
- 3.13. Техникийн нөхцлийг он оноор дугаарлан хадгалж, жагсаалтаар гаргаж дараа жилийн 1-р сард багтаан, цахилгааны шугам сүлжээний газрууд болон орон нутгийн цахилгаан станцууд эрчим хүчний тусгай зөвшөөрөл эзэмшигч компанийн техникийн нөхцөл олгох комисс яамны техникийн нөхцөл олгогчид тайлагнаж байна.
- 3.14. Техникийн нөхцөл авсан хэрэглэгчдийн ТЭЗҮ, зураг төслийг хянаж, барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах үед анх олгосон техникийн нөхцлийн шаардлагын биелэлтийг шалгаж, хэрэв зураг төслийн байгууллагатай тохиролцолгүйгээр өөрчлөлт оруулсан байвал зураг төсөл буюу угсралтад техникийн нөхцлийн дагуу зохих өөрчлөлт хийлгэнэ.
- 3.15. Техникийн нөхцөл олгосон өдрөөс хойш тухайн цахилгааны шугам сүлжээнд өөрчлөлт /хүч чадлыг ихэсгэх, багасгах, хэтийн төлвийн схемээр өөрчлөгдөх, татан буугдах гэх мэт/ орвол хангагч байгууллага тухай бүрд нь захиалагч буюу зураг төслийн байгууллагад мэдэгдэж техникийн нөхцлийг тодотгож байх ёстой.
- 3.16. Ажлын хэсэг нь Төрийн нарийн бичгийн даргын тушаалаар батлагдсан “Ажлын хэсгийн ажиллах журам”-ын хүрээнд үйл ажиллагаагаа явуулна.

Дөрөв. Техникийн нөхцөлийн агуулга

- 4.1. Тухайн барилга байгууламжийг барихдаа техник ашиглалтын дүрэм, заавар, “Цахилгаан байгууламжийн зураг төсөл, угсралтын дүрэм”, болон холбогдох бусад дүрэм, заавар, удирдамж, материалын шаардлагыг бүрэн хангаж, тухайн орон нутгийн байгаль цаг уурын нөхцөлд тохирсон, сүүлийн үеийн техникийн дэвшлийн шаардлагыг хангасан тоног төхөөрөмж сонгосон байхаар заана.
- 4.2. Техникийн нөхцөлд дараахь асуудлыг тусгасан байна. Үүнд:

- 4.1.1. Цахилгааны тооцоот дээд ачаалал,
- 4.1.2.Холболт хийх цэг (дамжуулах, түгээх шугам, дэд станц, анкер тулгуур), таслах залгах тоноглолын марк,
- 4.1.3.Холболтын схем,
- 4.1.4.Объектыг шинээр холбосноос болон хэрэглэгч хэрэглээгээ нэмэгдүүлсэнтэй холбогдуулан өргөтгөл хийх эсэх,
- 4.1.5.Цахилгаан эрчмийн хэмжих хэрэгсэл,
- 4.1.6.Объектод тавигдах тусгай шаардлага
- 4.1.7.Объектын ашиглалт, аюулгүй ажиллагааг хангах шаардлага
- 4.1.8.Иргэн, хуулийн этгээд нь объектыг барих явцад цахилгаан авах шаардлага гарвал түр холболт хийх цэг, хугацааг тодотгосон байх
- 4.1.9. Орчны тохижилтыг нөхөн сэргээх талаар авах арга хэмжээ
- 4.1.10. Техникийн нөхцөлийн хугацаа
- 4.1.11. Холбогдох тогтоол шийдвэрийн заалт

Тав. Бусад зүйл

- 5.1. Техникийн нөхцөлийн талаарх мэдээллийг салбарын вэб хуудсанд байршуулж, ил тод нээлттэй байх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 5.2.Техникийн нөхцөлийг дараахи үндэслэлээр хүчингүй болгоно. Үүнд:
 - 5.2.1.Техникийн нөхцөл авахын тулд техникийн хэрэглээний өгөгдлүүдээ зориуд буруу тодорхойлсон.
 - 5.2.2.Холболт хийх цэгийн хүчин чадлаас хэтрүүлэн техникийн нөхцөл олгосон бол.
 - 5.2.3.Техникийн нөхцөлийн хүчинтэй байх хугацаанд цахилгааны сүлжээнд холбогдоогүй тохиолдолд,
 - 5.2.4. Хугацаа дууссан техникийн нөхцөлөөр зураг төсөл боловсруулах, барилга байгууламж барихыг хориглоно.
 - 5.2.5. Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа дуусахаас 1 сарын өмнө сунгуулах хүсэлтийг ажлын хэсэгт гаргана. Хугацаа дууссан техникийн нөхцөлийг хүчингүйд тооцно.
- 5.3. Иргэн, хуулийн этгээд нь цахилгаан эрчим хүчээр хангах техникийн нөхцөл авсан тохиолдолд суурь хураамж болох 150000 (нэг зуун тавин мянган) төгрөгийг Эрчим хүчний хөгжлийн төв Голомт банк 2105010095 тоот дансанд тушаасан байна.
- 5.4. Техникийн нөхцөлтэй холбоотой гарсан маргааныг хууль, дүрэм, журмын дагуу шийднэ.
- 5.5.Энэхүү журмыг баталсан өдрөөс эхлэн мөрдөнө.

ЦАХИЛГААН ЭРЧИМ ХҮЧЭЭР ХАНГАХ ТЕХНИКИЙН
НӨХЦӨЛ ОЛГОХ ТОДРУУЛАХ ХУУДАС

Огноо

Дугаар

Улаанбаатар хот

1. Техникийн нөхцөл авахаар хүсэлт гаргаж буй аж ахуйн нэгж байгууллага, иргэний нэр хаяг, утас
.....
.....
2. Техникийн нөхцөл авах объектийн байршил, хаягийн тодорхойлолт.
.....
.....
3. Техникийн нөхцөл авах болсон шалтгаан.
.....
.....
5. Хэрэглэгчийн зэрэглэл, ажлын горим
.....
6. Цаашид өргөтгөх бол эхлэх, дуусах хугацаа, хүчин чадал (өргөтгөх бол хэзээ, ямар хүчин чадал нэмэгдэх кВт)
.....
7. Орон нутгийн засаг захиргааны газар олголтын тогтоолын дугаар, огноо
.....
8. Техникийн нөхцөлийн хүчинтэй хугацаа

ТОДРУУЛАХ ХУУДАС БИЧСЭН (нэр)